



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 147

Улаанбаатар хот

Г “Глейс таван зуун наян нэг” ХХК-ийн Г  
тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4 дэх заалт болон Хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 8.2.1 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Глейс таван зуун наян нэг” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсонтой холбогдуулан тус компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтыг “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 9.3-т заасны дагуу архивын нэгж болгон цэгцэлж, 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хорооны архивт хүлээлгэн өгөхийг “Глейс таван зуун наян нэг” ХХК /Б.Буяндэлгэр/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийт, харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт 10 хоногийн дотор тус тус мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



000264